

МОРЕ СТЕП МЭДЭЭ

MORE STEP – Mobility at risk: Sustaining the Mongolian Steppe Ecosystem

Дугаар. 1

www.morestep.org

2021 оны 9-р сар

Мэдээний тойм

Бид та бүхэнд МОРЕ СТЕП төслийн анхны мэдээний тоймыг хүргэж буйг хүлээн авна уу! “МОРЕ СТЕП – Нүүдэл, шилжилт хөдөлгөөний эрсдэлд: Монгол орны тал хээрийн экосистемийн тогтвортой байдлыг хадгалах” төсөл нь ХБНГУ-ын Засгийн Газрын Боловсрол, Судалгааны Яамны санхүүгийн дэмжлэгтэйгээр хоёр орны хамтарсан салбар хоорондын судалгааны төсөл юм. Төслийн хүрээнд бид нийгэм-экологийн системд гарч буй өөрчлөлтүүд тал нутгийн малчид, тэдний мал мөн зэрлэг өвсөн тэжээлтэн амьтдын нүүдэл, шилжилтэд хэрхэн нөлөөлж буйг судалдаг.

Талуудын уулзалт

Олон талт уулзалт нь зэрлэг амьтдыг хамгаалах, мөн тал нутгийн нүүдлийн мал аж ахуй, тогтвортой амьжиргаанд чиглэсэн төрийн бодлого, арга хэрэгслийг сайжруулахад чухал үүрэгтэй.

2019 онд бид орон нутгийн шийдвэр гаргагчид, малчид зэрэг олон талуудын уулзалт Улаанбаатарт зохион байгуулсан. Бид төслийн үйл явц, хүлээгдэж буй үр дүнг холбогдох талуудад танилцуулах, мөн шаардлагатай бодлого, ирээдүйн чиглэлийг тодорхойлохыг зорьсон. Уулзалтад оролцож төслийн цаашдын үйл ажиллагаанд чухал хувь нэмэр оруулсан нийт 52 төлөөлөгчидэд баярлалаа.




Талуудын уулзалт, 2019 оны 8-р сарын 28
Улаанбаатар хот

Бэлчээр зохицуулалтын бодлогууд

Монгол малчид хэдэн зууны туршид бэлчээрийн нөөцийг үр дүнтэй ашиглахын тулд нүүдлийн мал аж ахуй эрхэлсээр ирсэн. Малчдын нүүдэл байгалийн хатуу ширүүн нөхцлийг даван туулах, ургамлын гарцыг даган нүүдэллэж бэлчээрийг зүй зохистой ашиглахад чухал үүрэгтэй. Мөн малчид ургамлын гарц, шим тэжээл сайтай бэлчээрийг сонгон нүүх нь малаа өсгөх үндэс суурь болдог.

Бид талуудын уулзалтаар оролцогчдын туршлага, мэдлэгт үндэслэн бэлчээр зохицуулалттай холбоотой хамгийн чухал бодлогыг хамтран тодорхойлохыг зорисон. Оролцогчид “Бэлчээрийн мал аж ахуйн нүүдэл”, “Тогтвортой амьжиргаа”, “Зэрлэг амьтдын хамгаалал” гэсэн гурван сэдэвчилсэн бүлэгт хуваагдаж холбогдох нэн чухал бодлогууд, арга хэрэгслүүдийн үр дүнг хэлэлцсэн.



Сэдэвчилсэн бүлгүүдийн дэвшүүлсэн саналуудын материал

Бэлчээрийн мал аж ахуйн нүүдлийн талаар хэлэлцсэн оролцогчид “Бэлчээр, малчдын нүүдэлтэй холбоотой бодлого нь ихэнхдээ малчдад хүрдэггүй, харин бэлгэдлийн чанартай, амьдрал дээр хэрэгждэггүй” хэмээн онцолсон. Бэлчээр, нүүдлийн талаарх бодлогуудад хэрэгжилтийн хяналт сул бөгөөд мөн хүртээмжгүй санхүүжилт хүртээмжгүйгээс шалтгаалан бодлогууд үр дүнгүй байдаг хэмээн тодорхойлсон.

Мөн оролцогчид малчдын нүүдэл, бэлчээр зохицуулалтад дараах хүчин зүйлүүд чухал хэмээн үзсэн. Үүнд:

- Бэлчээрийн хүртээмж ба усны эх үүсвэр малчдын нүүдэлд нөлөөлдөг
- Малын тоо толгой нэмэгдэх нь бэлчээрийн чанарыг бууруулдаг
- Орон нутгийн бэлчээр ашиглалтын төлөвлөлт байгалийн нөөцийн зохицуулалтыг сайжруулахад чухал ач холбогдолтой

Эдгээр чухал хүчин зүйлсд дараах бодлогын зохицуулалтууд шаардлагатай:

- Малчдын нүүдлийг дэмжихийн тулд бэлчээр, усны хүртээмжийг зохицуулах байгууллагуудын тодорхой бус байдлыг багасгах
- Малын тоо толгойг хязгаарлах, чанарыг сайжруулах, малчдын хариуцлагыг нэмэгдүүлэх замаар бэлчээрийн тогтвортой ашиглалтыг сайжруулах
- Газар ашиглалт хариуцсан орон нутгийн албан тушаалтнуудын чадавхийг сайжруулах, оролцогч талуудын хооронд мэдээллийн солилцоо, хамтын ажиллагааг сайжруулах.

Цаашдын алхам: Бид 2021 оны 11-р сард хоёр дахь удаагийн талуудын уулзалтыг зохион байгуулна. Хэрэв оролцохыг хүсвэл morestep.mongolia@gmail.com хаяг руу и-мэйл явуулна уу.

**Талархан хүндэтгэсэн,
МОРЕ СТЕП төслийн хамт олон**

MORE STEP Workshop Report:

Matias, D.M., L. Drees, U. Kasymov, D. Nandintsetseg, B. Batbuyan, T. Dashpurev, U. Dorj, G. Gonchigsumlaa, T. Müller, I. Ring & M. Mehring (2020): Mobility at risk: Sustaining the Mongolian steppe ecosystem – developing a vision. Stakeholder involvement and identification of drivers and pathways towards sustainable development. ISOE-Materialien Soziale Ökologie, Nr. 62. Frankfurt am Main: ISOE – Institut für sozial-ökologische Forschung